



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэгийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2025/137/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.open.audit.mn

Дундговь аймаг

2025 он

Өмнөговь аймгийн Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Утас: 70533539

Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552

Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр

Утас: 70593113

Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn

Аудитор: Ц.Лүндэгмаа

Утас: 99026829

Цахим хаяг: Lundegmaajn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.02.24 № 55
танай _____-ны № _____-г

ДУНДГОВЬ АЙМГИЙН УЛАМЖЛАЛТ
АНАГААХ УХААНЫ НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГА
Х.ЧИРЧИНСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 сарын сарын 01-ээр төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 111.4 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалаас гүйцэтгэлээр санхүүжих санхүүжилтийн авлага 133.2 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Тайлант онд жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 72.0 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлж буцаан олгохдоо Эрүүл мэндийн яамнаас төлөвлөгөөгүйгээр зарцуулах эрхийг нээж өгсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт, 33 арга хэмжээг тусгаж хэрэгжилтийг хангаж ажилласнаар Эрүүл мэндийн газрын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 94.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	159,648,071.65	264,188,432.81
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,056,286.14	47,661,772.69
312	Банканд байгаа бэлэн мөнгө	4,056,286.14	47,661,772.69
3121	Төгрөг	4,056,286.14	47,661,772.69
31211	Төрийн сангийн харилцах	-	43,154,126.55
31218	Ахмадын сангийн харилцах	4,056,286.14	4,507,646.14
33	АВЛАГА	95,989,160.69	155,367,523.00
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,793,635.50	
332	Төлбөртэй үйлчилгээний авлага	22,177,000.00	155,367,523.00
335	Бусад авлага	72,018,525.19	-
3351	Байгууллагаас авах авлага	72,018,525.19	-
35	БАРАА МАТЕРИАЛ	59,602,624.82	61,159,137.12
351	Түүхий эд материал	32,752,368.82	35,262,637.12
3511	Тусгай зориулалттай материал	10,184,853.31	17,073,453.31
3512	Эм боох материал	22,567,515.51	18,189,183.81
354	Хангамжийн материал	26,850,256.00	25,896,500.00
3541	Бичиг хэргийн материал	2,170,800.00	2,242,300.00
3542	Аж ахуйн материал	19,680,180.00	19,151,620.00
3545	Барилгын засварын материал	1,300,000.00	1,190,000.00
3546	Хүнсний материал	201,276.00	143,580.00
3547	Бусад хангамжийн материал	3,498,000.00	3,169,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	516,426,349.71	487,650,574.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	516,426,349.71	487,650,574.90
392	Биет хөрөнгө	505,361,682.96	477,585,908.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	442,051,710.00	442,051,710.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(45,011,905.20)	(54,014,286.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	22,000,000.00	22,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(5,958,333.29)	(11,458,333.25)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	106,499,639.58	108,619,439.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,364,872.84)	(55,942,750.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,636,100.00	40,178,100.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,490,655.29)	(13,847,971.63)
393	Биет бус хөрөнгө	11,064,666.75	10,064,666.79
39301	Програм хангамж	5,200,000.00	5,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,283,333.25)	(3,283,333.21)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,148,000.00	8,148,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	676,074,421.36	751,839,007.71
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	676,074,421.36	751,839,007.71
51	Засгийн газрын хувь оролцоо	676,074,421.36	751,839,007.71
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	435,889,886.01	435,889,886.01
5E+05	Өмч: - төрийн	435,889,886.01	435,889,886.01
512	Хуримтлагдсан үр дүн	173,298,885.35	249,063,471.70
5121	Өмнөх үеийн үр дүн	173,298,885.35	173,298,885.35

5122	Тайлант үеийн үр дүн		75,764,586.35
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	66,885,650.00	66,885,650.00
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	676,074,421.36	751,839,007.71

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	769,581,732.73	963,460,870.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	55,310,432.73	53,691,865.40
120	Нийтлэг татварын бус орлого	55,310,432.73	53,691,865.40
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	50,052,700.00	53,691,865.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,764,200.00	45,450,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,288,500.00	8,241,865.40
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	5,257,732.73	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	714,271,300.00	909,769,005.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	61,905,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		61,905,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	714,271,300.00	847,864,005.00
13402	Эрүүл мэндийн даатгалын сангаас	714,271,300.00	847,864,005.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	749,140,345.53	887,696,284.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	737,940,345.53	864,905,374.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	737,940,345.53	864,905,374.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	430,036,373.32	541,398,726.48
210101	Үндсэн цалин	280,382,863.60	336,322,133.57
210102	Нэмэгдэл	96,565,971.89	106,625,744.91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,878,991.53	54,119,000.00
210104	Урамшуулал	40,208,546.30	44,331,848.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,557,708.54	67,451,597.17
210201	Тэтгэврийн даатгал	37,099,241.81	49,501,047.79
210202	Тэтгэмжийн даатгал	4,364,616.68	4,738,415.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,902,026.28	2,424,582.62
210204	Ажилгүйдлийн даатгал	2,462,590.41	2,157,410.31
210205	Эрүүл мэндийн даатгал	8,729,233.36	8,630,141.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,287,893.00	51,628,711.56
210301	Гэрэл, цахилгаан	8,455,144.00	8,905,354.56
210302	Түлш, халаалт	28,261,093.00	30,656,101.00
210303	Цэвэр бохир ус	9,571,656.00	12,067,256.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,730,127.00	12,514,416.80
210401	Бичиг хэрэг	4,076,950.00	1,710,250.00
210402	Тээвэр, шатахуун	1,611,635.00	1,686,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,487,290.00	1,703,754.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,299,952.00	1,826,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,253,000.00	3,242,260.00
210408	Бараа материал акталсны зардал	5,001,300.00	2,345,452.80
2105	Нормативт зардал	113,924,046.98	112,859,987.90
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	85,030,549.98	82,047,088.90

210502	Хоол хүнс	27,938,497.00	29,982,899.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	955,000.00	830,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,025,300.00	20,535,100.00
210601	Багаж хэрэгсэл	140,000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын зардал	135,000.00	
210604	Урсгал засвар	15,750,300.00	20,535,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,456,000.00	1,994,000.00
210702	Дотоод албан томилолт	1,456,000.00	1,994,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,869,524.80	8,946,554.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,162,100.00	3,208,880.00
210802	Аудит, батлгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		74,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	25,132.80	54,632.80
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,800.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,734,900.00	4,609,200.00
210807	Газрын төлбөр	54,592.00	54,592.00
210809	Улсын мэдээллийн маягтны зардал	145,000.00	225,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,053,371.89	47,576,280.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,601,450.00	3,548,640.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,252,000.00	1,010,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,199,921.89	43,017,640.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,200,000.00	22,790,909.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,200,000.00	11,790,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,200,000.00	11,790,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	11,000,909.13
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		11,000,909.13
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	20,441,387.20	75,764,586.35
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (3)=(145-225)	20,441,387.20	75,764,586.35
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	20,441,387.20	75,764,586.35

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	734,858,500.00	898,047,007.19
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	42,764,200.00	121,468,525.19
120	Нийтлэг татварын бус орлого	42,764,200.00	121,468,525.19
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	42,764,200.00	121,468,525.19
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,764,200.00	45,450,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,000,000.00	76,018,525.19
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	692,094,300.00	776,578,482.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	61,905,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	0.00	61,905,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		

		692,094,300.00	714,673,482.00
13402	эрүүл мэндийн дааьгалын сангаас		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	777,089,854.35	848,441,520.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	777,089,854.35	848,441,520.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	693,871,329.16	825,650,611.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	434,830,008.82	543,605,090.98
210101	Үндсэн цалин	285,176,499.10	341,529,595.91
210102	Нэмэгдэл	96,565,971.89	105,218,375.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,878,991.53	53,806,289.47
210104	Урамшуулал	40,208,546.30	43,050,830.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,557,708.54	67,451,597.17
210201	Тэтгэврийн даатгал	37,099,241.81	44,820,597.17
210202	Тэтгэмжийн даатгал	4,364,616.68	5,657,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,902,026.28	2,828,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,462,590.41	2,828,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,729,233.36	11,315,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,287,893.00	51,628,711.56
210301	Гэрэл, цахилгаан	8,455,144.00	8,905,354.56
210302	Түлш, халаалт	28,261,093.00	30,656,101.00
210303	Цэвэр бохир ус	9,571,656.00	12,067,256.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,166,277.00	10,604,004.00
210401	Бичиг хэрэг	3,052,400.00	1,654,750.00
210402	Тээвэр, шатахуун	1,611,635.00	1,686,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,487,290.00	1,703,754.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,299,952.00	1,826,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,715,000.00	3,732,800.00
2105	Нормативт зардал	108,841,167.00	113,623,913.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	80,025,964.00	82,868,710.00
210502	Хоол хүнс	27,860,203.00	29,925,203.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	955,000.00	830,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,998,300.00	23,238,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,999,000.00	2,620,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын зардал	135,000.00	
210604	Урсгал засвар	16,864,300.00	20,618,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,456,000.00	1,994,000.00
210702	Дотоод албан томилолт	1,456,000.00	1,994,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,880,524.80	8,946,554.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,766,100.00	3,208,880.00
210802	Аудит, батлгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	74,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	25,132.80	54,632.80

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,800.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,141,900.00	4,609,200.00
210807	Газрын төлбөр	54,592.00	54,592.00
210809	Улсын мэдээллийн маягтны зардал	145,000.00	225,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,853,450.00	4,558,640.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,601,450.00	3,548,640.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,252,000.00	1,010,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,218,525.19	22,790,909.13
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,200,000.00	11,790,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,200,000.00	11,790,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	72,018,525.19	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,018,525.19	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	11,000,909.13
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		11,000,909.13
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(42,231,354.35)	49,605,486.55
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	16,770,000.00	6,000,000.00
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,770,000.00	6,000,000.00
	Дотоод эх үүсвэрээр	16,770,000.00	6,000,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,770,000.00	6,000,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(16,770,000.00)	(6,000,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(59,001,354.35)	43,605,486.55
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	63,057,640.49	4,056,286.14
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,056,286.14	47,661,772.69

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,889,886.01	66,885,650.00	6,309,546.45	509,085,082.46
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	435,889,886.01	66,885,650.00	6,309,546.45	509,085,082.46
3	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			(2,423,760.19)	(2,423,760.19)
4	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,889,886.01	66,885,650.00	173,298,885.35	676,074,421.36
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	435,889,886.01	66,885,650.00	173,298,885.35	676,074,421.36
6	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			75,764,586.35	75,764,586.35

7	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	435,889,886.01	66,885,650.00	249,063,471.70	751,839,007.71
---	---------------------------------------	----------------	---------------	----------------	----------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,023,145,400.00	839,891,971.51	183,253,428.49	82.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,023,145,400.00	839,891,971.51	183,253,428.49	82.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	988,745,400.00	828,101,971.51	160,643,428.49	83.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	601,574,500.00	543,605,090.98	57,969,409.02	90.4
210101	Үндсэн цалин	360,897,000.00	341,529,595.91	19,367,404.09	94.6
210102	Нэмэгдэл	178,852,600.00	105,218,375.30	73,634,224.70	58.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,494,300.00	53,806,289.47	-	176.4
210104	Урамшуулал	31,330,600.00	43,050,830.30	-	137.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,721,800.00	67,451,597.17	9,270,202.83	87.9
210201	Тэтгэврийн даатгал	54,090,800.00	44,820,597.17	9,270,202.83	82.9
210202	Тэтгэмжийн даатгал	5,657,700.00	5,657,700.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,828,900.00	2,828,900.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,828,900.00	2,828,900.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	11,315,500.00	11,315,500.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,905,000.00	51,628,711.56	12,276,288.44	80.8
210301	Гэрэл, цахилгаан	15,968,000.00	8,905,354.56	7,062,645.44	55.8
210302	Түлш, халаалт	30,657,000.00	30,656,101.00	899.00	100.0
210303	Цэвэр бохир ус	17,280,000.00	12,067,256.00	5,212,744.00	69.8
2104	Хангамж, бараа материалын зардал	12,307,500.00	10,604,004.00	1,703,496.00	86.2
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	1,654,750.00	345,250.00	82.7
210402	Тээвэр, шатахуун	2,524,500.00	1,686,700.00	837,800.00	66.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,400,000.00	1,703,754.00	-	121.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,083,000.00	1,826,000.00	257,000.00	87.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,300,000.00	3,732,800.00	567,200.00	86.8
2105	Нормативт зардал	152,825,200.00	113,623,913.00	39,201,287.00	74.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	107,077,600.00	82,868,710.00	24,208,890.00	77.4
210502	Хоол хүнс	40,997,600.00	29,925,203.00	11,072,397.00	73.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,750,000.00	830,000.00	3,920,000.00	17.5
2106	Эд хогшил, урсгал засварын				55.7

	зардал	52,500,000.00	29,238,100.00	23,261,900.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	8,620,000.00	11,380,000.00	43.1
210603	Хөдөлмөр хамгааллын зардал	3,000,000.00		3,000,000.00	
210604	Урсгал засвар	29,500,000.00	20,618,100.00	8,881,900.00	69.9
2107	Томилолт, зочны зардал	4,375,000.00	1,994,000.00	2,381,000.00	45.6
210702	Дотоод албан томилолт	4,375,000.00	1,994,000.00	2,381,000.00	45.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,002,800.00	8,946,554.80	12,056,245.20	42.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,950,000.00	3,208,880.00	7,741,120.00	29.3
210802	Аудит, батлгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	74,250.00	75,750.00	49.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	54,632.80	45,367.20	54.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00		100,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,667,000.00	4,609,200.00	4,057,800.00	53.2
210807	Газрын төлбөр	70,800.00	54,592.00	16,208.00	77.1
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	20,000.00		20,000.00	0.0
210809	Улсын мэдээллийн маягтны зардал	225,000.00	225,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,533,600.00	1,010,000.00	2,523,600.00	28.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,300.00		33,300.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,500,300.00	1,010,000.00	2,490,300.00	28.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,400,000.00	11,790,000.00	22,610,000.00	34.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,400,000.00	11,790,000.00	22,610,000.00	34.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,400,000.00	11,790,000.00	22,610,000.00	34.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,023,145,400.00	883,046,098.06	140,099,301.94	86.3
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	61,905,000.00	50,904,090.87	11,000,909.13	82.2
132001	Орон нутгийн төсвөөс	61,905,000.00	50,904,090.87	11,000,909.13	82.2
	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	807,162,600.00	714,673,482.00	92,489,118.00	88.5
	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	807,162,600.00	714,673,482.00	92,489,118.00	88.5
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	154,077,800.00	117,468,525.19	36,609,274.81	76.2
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,040,800.00	45,450,000.00	-	108.1
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	112,037,000.00	72,018,525.19	40,018,474.81	64.3
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,056,286.14	4,056,286.14	

	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		47,661,772.89	- 47,661,772.89	
	АЖИЛЛАГСДЫН ТОО	25	18	7	72.0
	Удирдах ажилтан	1	1	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	14	11	3	78.6
	Үйлчлэх ажилтан	10	6	4	60.0
	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	17	8	68.0
	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч /ТҮЭМ/	14	11	3	78.6
	Төрийн үйлчилгээний буёад албан хаагч /ТҮ/	11	6	5	54.5

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,408.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 4,982.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 742.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, цалин, урамшуулалтай холбоотой 5,384.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой 1,300.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж тус тус хүргүүлээ.

Залруулсан алдаа:

Аудитаар нийт 4,982.0 мянган төгрөгийн 1 алдаа¹ илрүүлж аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

Тайлант хугацаанд эм ороох боох материалын дансанд эмнэлэгийн багаж, нэг удаагийн халат, комбинзон бүртгэж тайлагнасан.

Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 6,126.6 мянган төгрөгийн зөрчил² илэрч, 742.6 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх 1 төлбөрийн акт, 5,384.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, зөрчил арилгах зөвлөмж хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

1. Байгууллагын жолоочийн албан үүргийг гүйцэтгэж байгаа ажилтанд эд хариуцагчийн нэмэгдэл цалин тооцож олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2-т зааснаар /Төрийн албаны тухай хуульд тусгайлан зааснаас өөрөөр төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс тогтоохгүй байхыг төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч нарт даалгасугай/ гэж заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон 742.6 мянган төгрөгийн цалинг орон нутгийн орлогын 100080000955 тоот дансанд, төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

Байгууллагын удирдлага нягтлан бодогч, нярав нарын ажлыг улирал бүр дүгнэж, үр дүнгийн урамшууллыг тайлант хугацаанд тухай бүр олгосон боловч 2023 санхүүгийн тайлангийн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан үндэслэлээр 2 сарын үндсэн цалингийн урамшуулал давхардуулан олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1- /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т /Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:/, 15.1.3-т /хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;/ мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-т /байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох/ гэж заасныг, мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.3 Зөвлөмж

3.3.1 Бараа материалын данстай холбоотой

Илрүүлэлт:

Аж ахуйн материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэж тайлагнасан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т */Үнэн зөв байх/*, мөн хуулийн 20.2.4-д */Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах/* заасныг, мөн нийцсэн бөгөөд оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийг эдийн засгийн ангиллын дагуу үнэн зөв бүртгэж, үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэх зөвлөмжийн хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Төрийн аудитын байгууллагад нотлох баримтын хамт ирүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант хугацаанд эм ороох боох материалын дансанд эмнэлэгийн багаж, нэг удаагийн халат, комбинзон бүртгэж тайлагнасан.	1	4,982.0			1	4,982.0	1	4,982.0		
Дүн	1	4,982.0	-	-	1	4,982.0	1	4,982.0	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Байгууллагын жолоочийн албан үүргийг гүйцэтгэж байгаа ажилтанд эд хариуцагчийн нэмэгдэл цалин тооцож олгосон.	1	742.6	1	742.6						
Байгууллагын удирдлага нягтлан бодогч, нярав нарын ажлыг улирал бүр дүгнэж, үр дүнгийн урамшууллыг тайлант хугацаанд тухай бүр олгосон боловч 2023 санхүүгийн тайлангийн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан үндэслэлээр 2 сарын үндсэн цалингийн урамшуулал давхардуулан олгосон.	1	5,384.0			1	5,384.0				
Аж ахуйн материалын дансанд үндсэн хөрөнгийг бүртгэж тайлагнасан. / Посын төхөөрөмж/	1	1,300.0					1	1,300.0		
Дүн	3	7,426.6	1	742.6	1	5,384.0	1	1,300.0	-	-

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо	Санал дүгнэлтийн хэлбэр
---	-----------------------------	--------------------------	-------------------------

		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			